

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ**Иргэн, захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэр
гүйцэтгэх ажиллагаа****МОНГОЛ УЛСАД ШҮҮХИЙН ШИЙДВЭР БИЕЛҮҮЛЭЭГҮЙ
ЭТГЭЭДЭД ОНОГДУУЛЖ ИРСЭН ХУУЛЬ ЗҮЙН ХАРИУЦЛАГЫН
УЛАМЖЛАЛ****THE TRADITION OF LEGAL LIABILITY IMPOSED ON PERSONS
WHO HAVE FAILED TO EXECUTE COURT DECISIONS IN
MONGOLIA****Я.Батгэрэл***ДХИС-ийн Сургалт судалгааны 403-р анги-Шүүхийн
шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Иргэний
шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн профессор, доктор
(Ph.D), хурандаа*

Товч утга: Ирээдүй өнөөдрөөс биш чухамдаа өчигдрөөс эхэлдэг билээ. Түүх эдүгээгийн хоорондох дотоод гүнзгий хэлхээ холбоо нь өнгөрснийг танин мэдэх бололцоог олгоод зогсохгүй ирээдүйн тухайн зөв төсөөллийг бий болгодог. Иймээс ч үе үеийн мэргэд ирээдүй бол мартагдсан өчигдөр гэж нэгэн дуугаар зөвшөөрсөн байдаг. (Алтангэрэл.Т, 2003)

Эрүүгийн хуульд шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хууль зүйн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалт Монгол Улсын улс төр, эдийн засаг, нийгмийн, хөгжил, эрх зүйн сэтгэлгээ, хууль зүйн шинжлэх ухааны хөгжлийн түвшинтэй уялдан өөрчлөгдөн шинэчлэгдсээр өнөөг хүрчээ.

Шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд оногдуулж ирсэн хууль зүйн хариуцлагын түүхэн уламжлалыг судлахдаа эрүүгийн хариуцлага хүлээлгэх чиглэлээр батлан гаргасан эрх зүйн эх сурвалжуудад түүхчилсэн дүн шинжилгээ хийн тоймлон авч үзсэн. Судалгааны ажлын хүрээнд шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй этгээдэд эрүүгийн хариуцлага

хүлээлгэж ирсэн түүхэн уламжлалыг Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн ялсан 1911 оны 12 дугаар сарын 29-ний өдөр Богд хаант Монгол Улсын Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэх яам байгуулагдсан үеэс эхлэн эрх зүйн эх сурвалжийн хүрээнд эрэмбэлэн судалж, уг асуудлыг өнгөрсөн, одоо, ирээдүй гурван цагийн хэлхээн дэх залгамж чанараар нь үечлэн тодорхойлохыг зорилоо. Ингэхдээ орчин цагийн шүүх байгууллагын тогтолцооны эхлэл болсон түүхэн цаг хугацааг сонгож, шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангаагүй этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тогтоосон эрх зүйн хэм хэмжээний агуулгын хүрээнд судлан үзлээ.

Түлхүүр үгс: Шүүхийн шийдвэр, шийдвэр гүйцэтгэгч, эрүүгийн хариуцлага, ял шийтгэл, хариуцлага тооцох, эрүүгийн хэрэг.

Abstract: The future does not begin today, but rather, it truly begins from yesterday. The deep internal connection between history and the present not only allows us to understand the past but also creates a proper vision for the future. For this reason, great thinkers throughout the ages have unanimously agreed that the future is a forgotten yesterday. (Altangerel.T, 2003)

In the Criminal Law, the legal regulation to hold persons accountable for failure to execute court decisions has continuously evolved in accordance with Mongolia's political, economic, social, developmental, legal consciousness, and the level of advancement of legal science.

When studying the historical tradition of legal liability imposed on persons who have failed to comply with court decisions, a historical analysis was conducted focusing on legal sources related to the imposition of criminal liability. As part of the research, the historical tradition of imposing criminal liability on persons who failed to execute court decisions was examined chronologically from the establishment of the Ministry of Justice and Internal Affairs on December 29, 1911, after the victory of the National Liberation Movement of Mongolia, which was responsible for judicial rulings, under relevant legal sources. The study aimed to define the issue through the continuity of past, present, and future time dimensions. In doing so, the historical period marking the beginning of the modern judicial system was selected, and the content of legal norms establishing liability for failure to execute court decisions was examined.

Key words: Court decision, court enforcement officer, criminal liability, punishment, to hold accountable, criminal case.

ҮНДСЭН ХЭСЭГ

Богд хаант Монгол Улсын үеийн хууль тогтоомж:

Монгол Улс 1911 оны 12 дугаар сарын 29-ний өдөр Богд Жавзандамба хутагтыг шинэ тулгар улсын хаанд өргөмжлөн, Монгол Улсыг Манжийн ноёрхлоос чөлөөлөн тусгаар улс болсныг зарлан тунхаглажээ. (Болдбаатар.Ж, 2009) 1914-1918 онд батлагдсан “Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг” нь 65 дэвтэртэйгээр эмхэтгэгдсэн байна. Богд хаант Монгол Улсын Зарлигаар тогтоосон хууль зүйлийн бичгийн 10 дугаар дэвтрийн нэгэн зүйлд торгох малын тоог мөнгөөр орлуулан тооцох тухай зохицуулжээ. Тухайлбал, Ес торгох малын тогтоосон тоог “Торгох ялын нэгэн есөн малд мөнгө 27 лан, долоон малд мөнгө 21 лан, таван малд мөнгө 15 лан, гурван малд мөнгө 9 лан, нэгэн малд мөнгө 3 лан таацуулагтун ” хэмээн 1 малыг 3 лан мөнгөөр үнэлж тогтоожээ. “Аливаа хэрэг халдаж торговоос зохих малыг цөм хэрэг бараад яамны бичиг хүрсэн өдрөөс эхлэн ес бүр гучин өдөр хугацаа өгч, дуусган тушаалга. Өөр өөрийн таван өдөр илүү хугацаа хугац. Хугацаа дүүрч тушаалгахгүй болбоос тайж, түшмэдэд малын тоог бодохгүй ер тушаалгах тоонд нь хүрэхгүй болбоос даруй жинсийг байлгаж хугацаа сунгаж хөөн тушаалга. Гуравдугаар хугацаа сунгахад хүрээд үнэхээр чинээгүй дуусган тушаалгаж үл чадагчдыг тайжийн зэргийг байлгаж гурван жил эндэгдэлгүй болбоос зэрэг дахиул. Хөөж тушаалгахыг хэлтрүүл. Ял нь тайжийн зэргийг байлгахад зогсогтун. Түшмэд болбоос даруй түшмэл эвд. Харц хүн мал тушаалгахад үл хүрэх тоо нэг, хоёр болбоос далан таван ташуур, долоо, есөд хүрвээс зуун ташуур занч. Нэгэн есөөс дээш болбоос нэмүүлэн нэг сарын дөнгө дөнгөлүүл. Хөөж тушаалгахыг хэлтрүүл. Ял нь зуун ташуур занчиж нэгэн сарын дөнгө дөнгөлүүлэхэд зогсогтун ” гэсэн байна.

Сийрүүлбэл, Торгох ял шийтгэлд өгөх малыг шүүх яамны бичиг очсон өдрөөс эхлэн тоолоод есөн мал бүрд 30 хоногийн хугацаа өгч торгуулийг бүрэн төлүүл. Төлөөгүй бол эдгээр хугацаа бүрд нэмж 5 хоногийн хугацаа өг. Хугацааг дуусахад ялд авах малыг эсхүл мөнгийг бүрэн төлөхгүй бол тайж, түшмэл хүн болбоос хэргэм зэргийг /жинс/ нь хурааж дахин торгууль төлөх хугацаа олгон торгуулийг тушаалга. Дээрх 3-н удаагийн сунгасан хугацаанд ялд авах малыг өгөөгүй торгуулсан этгээд нь тайж бол тайжийг хэргэм зэргийг хасаж 3 жилийн дотор алдаа эндэгдэл гаргаагүй бол эргэн тайжийн зэргийг олгох, түшмэл бол түшмэлийн зэргийг нь болиулж торгуулийн малыг гаргуулахгүй байхаар, харц хүн бол ялд өгөх

малын тоо 1-2 дутсан бол 25 ташуур, 3-4 дутсан бол 50 ташуур, 5-6 дутсан бол 75 ташуур, 7-9 дутсан бол 100 ташуурдаж өгөх малын тоо нэгэн 9-өөс дээш бол нэмж нэг сар дөнгөлөх ялаар шийтгээд ялд авах малын төлбөрөөс чөлөөлдөг байж.

Энэ нь есөөр торгуулсан этгээд торгуулиа малаар эсвэл мөнгөөр төлөх боломжийг олгосон мөн төлөх хугацааг торгуулийн хэмжээнээс хамаарч ялгамжтай тогтоосон, торгуулийн малыг төлж чадаагүй бол хүлээлгэх хариуцлагыг тайж, түшмэл албан тушаалтан байвал албан тушаалаас огцруулах, энгийн ард байвал ташуурдан шийтгэж байхаар тодорхой зааж өгсөн байна. Үүнээс үзвэл шүүхийн шийтгэх бичгээр малаар торгуулсан этгээд ялынхаа малыг өгөхгүй бол хүлээлгэх хариуцлага байснаас гадна энэ ялын малыг авч засагт тушаах үүрэг бүхий өнөөгийн шийдвэр гүйцэтгэгчтэй адил тайж хэмээх албан тушаалтан байжээ. (Зая, 2016)

МАН-ын III их хурал 1921 оны 8 сарын 04-өөс 9 дүгээр сарын 4-ний өдрүүдэд болж 12 асуудал хэлэлцсэний нэгт, “Шүүх яамны илтгэлд гарсан тогтоол” гэдэг бичиг баримт хамаарах бөгөөд уг тогтоолын 10 дахь хэсэгт “Аливаа өр ширийн хэрэгтэй хүнийг гянданд хорихыг зогсоох нь зүйтэй боловч эрхлэх яамны дотор эл хүнийг ялган салгаж гүйцэтгэвэл зохино” (Баярсайхан, Монгол улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал, 2011) гэснээс үзвэл Богд хаант засгийн үед өр төлбөртэй этгээдийг гянданд хорьж байсан бололтой. Ардын хувьсгал ялсны дараа улс орны бие даасан тогтвортой байдлыг хангах, Манжийн харгис хууль цаазыг халах, нийгмийн дэг журмыг хангах, хууль, журмыг зохион гаргаж хэрэгжүүлэх ажил эрчимтэй хийгдсэн.

Үүний нэг болох 1923 онд батлагдсан Нийслэл хүрээний цагдан сэргийлэх хорооны хууль дүрмийн Цагдан цээрлүүлснийг зөрчигсдийг яллах хууль хэмээх 1 дүгээр бүлгийн 2 дугаар зүйлд “Аливаа хорихыг нь цагдан сэргийлэх хорооны газар хоривол зохино”, 3 дугаар зүйлд “Аливаа торгосон мөнгийг 5 өдрийн хугацааны дотор гүйцэтгэн тушаавал зохино гэжээ. Хэрэв хугацаа өнгөрөөд гүйцэтгэн тушаах чинээгүйг нь бол төгрөг нэг бүрд нугалж нэг өдөр хорино гэсэн заалтад хорих ялыг хаана эдлүүлэх, торгуулийн ялыг ямар хугацаанд биелүүлэх, хөрөнгө мөнгөгүй бол хорих ялаар дүйцүүлэн солих журмыг тогтоосон нь шүүхийн шийдвэрээр оногдуулсан ялыг гүйцэтгэх ажиллагааны журам тогтоосон хэм хэмжээ мөн.

Монгол Улсад 1921 онд Ардын хувьсгал ялж тухайн үед Монгол орон "социализм"-д хүрэх чиг баримжааг сонгон түүний онол, үзэл баримтлалын дагуу түүнд тохирсон нийгэм, улс төр, эдийн засгийн зохих тогтолцоог бүрдүүлэхийн тулд өөртөө тохирсон эрх зүйн үндсийг бий болгох зайлшгүй шаардлага бий болсон. Энэ л үүднээс нийгмийн харилцааг ерөнхийлөн зохицуулах хуульчилсан актуудыг шинээр батлан гаргасан нь дундад зууны үеийн нийгэм төрийн байгуулал, эрх зүйн журмыг халах зорилтыг хангахад чиглэсэн эрх зүйн хэм хэмжээгээр илэрч байсан юм. Тухайлбал, шүүн таслах ажиллагаатай холбоотой 1921 оны 07 дугаар сарын 30-ны Ардын засгийн газрын YIII хурлаар Эрүү шүүлтийн тухай тогтоол гаргасан ба уг тогтоолын (Амарсанаа. Ж, 2008) аравдугаар зүйлд "Монгол хүн гэрээ, гэрчгүйд хэргийг хүлээхгүй бол юуны урьд эрүү шүүлт хэрэглэхгүйгээр үнэнийг олохыг хичээх ба хэрэв өчиг илрэхгүйд хүрвэл шүүлтийн зохисын нь үзэж хэвээр хэмнэн хэрэглүүлэхээр тогтов" гэжээ.

БНМАУ-ын 1926 оны Шүүх цаазын бичиг:

БНМАУ-ын Анхдугаар Үндсэн хуулийг 1924 онд баталсны дараа түүнд хууль тогтоомжийг нийцүүлэх, хууль цаазыг зохион боловсруулах бэлтгэл ажил явагдсаны үр дүнд Монгол Улсын анхны төрөлжсөн эрүүгийн хууль "Шүүх цаазын бичиг" нэртэйгээр 1926 онд батлан гаргаж мөрдүүлсэн билээ. (Гантөмөр.Г, Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг, 2005)

Шүүх цаазын бичгийн 12 дугаар бүлгийг "Шүүх таслах явдалд тэрслэх нь" гэж нэрлээд 72-р зүйлд Эрүүгийн ба иргэний хэрэг дор холбогдсон этгээдийн гэмийг тодорхойлох зэрэг эд мөрийн баримт болох зүйлүүдийг санаатайгаар устгах ба хувьсгах нь жич: тэр мэтийн хуурамч зүйлийг хэрэглэх, албаны юмыг ба орон савыг битүүмжилсэн албаны тамга тэмдэг зэргийг эвдэх буюу арилгаваас 1-3 жил хүртэл гянданд хорих буюу 600-1800 төгрөг хүртэл торгоно, 77-р зүйлд "Тус улсын хязгаараас Шүүн таслах газрын тогтоолоор нэгэнт хөөгдсөн гадаад улсын харьяат нар хэрэв зоргоороо эргэж ирвээс 1 жилээс 3 жил хүртэл гянданд хорино, 82-р зүйлд Аливаа хүн албаны газраас хэргийн учир зайлж саатуулсан газар орноос дур зоргоороо зайлан гарвал 3 сар гянданд хорих буюу эсвэл 150 төгрөг хүртэл торговол зохино, 83-р зүйлд Аливаа хүн Шүүн таслах газрын тогтоолоор ялаар ба эрх чөлөөгөө хасагдсан бөгөөтөл дураараа зөрчсөн бол 6 сар хүртэл гянданд хорих буюу 300 төгрөг хүртэл торгоно (Адъяабазар.Д, 1998) гэж тус тус заасан байх бөгөөд энэ нь шүүхийн шийдвэрийг

биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрлийг гянданд хорих эсвэл 300 төгрөг хүртэл торгох ялаар шийтгэх байдлаар зохицуулсан байна.

Мөн хуулийн 11 дүгээр зүйлд Ял торгууль дор төгрөг ба мөнгөөр тогтооно. Хэрэв цааз хуулийн дотор ялын дээд хэмжээ нь нэгэн зуун төгрөгөөс дээш бус болбоос ял торгохыг даган 10 төгрөгөөс дорогш /доош/ торгож үл болно. Ял тушаах хугацааг Шүүх таслах газрын тогтоон шийтгэсэн өдрөөс хойш, нэгэн жил хүртэл сунгаж болно. Хэрэв ялыг тушаах чиггүй бөгөөс нэгэн төгрөгт нэгэн өдөр бодож түүний бисийг хорихгүйгээр үйлдвэр хийлгэнэ. Үүн дор тайлбарлах нь: Ялыг шударгаар тушаахгүй ялаас зайлсхийсэн болбоос түүний хувийн хөрөнгө хогшлыг албан газраас данс тэмдэг үйлдэж худалдах буюу банкны зэрэг газарт хадгалуулсан мөнгө, зоос, жич: бусдаас авах зүйл байваас тэдгээрийг битүүмжлэх зэргээр тушаалгаваас зохино (Адъяабазар.Д, 1998) гэсэн нь шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийсэн этгээдэд иргэний эрх зүйн хариуцлага хүлээлгэх үндсийг тодорхойлжээ.

БНМАУ-ын 1929 оны Шүүх цаазын бичиг:

БНМАУ-ын Засгийн газрын 1929 оны 9 сарын 23-ны өдрийн 30 дугаар хурал, Улсын 14 дүгээр бага хурлаар Шүүх цаазын бичгийг шинэчлэн найруулан баталж мөрдөж эхэлсэн байна. Уг Шүүх цаазын бичигт Шүүхийн шийдвэр үл биелүүлэх гэмт хэргийн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой дараах заалтыг тусгажээ. Шүүх цаазын бичгийн 11 дүгээр бүлгийг “Шүүх таслах явдалд тэрслэх нь” гэж нэрлээд 77-р зүйлд “Эрүүгийн ба иргэний хэрэгт холбогдсон этгээдийн гэмийг тодорхойлох эд мөрийн зэрэг баримт болох зүйлүүдийг санаатайгаар устгах ба хувьсгах жич: тэр мэт хуурамч зүйлийг хэрэглэх буюу аливаа албаны юм ба орон савыг битүүмжилсэн албаны тэмдэг зэргийг эвдэх буюу арилгаваас 3 жил хүртэл хорих буюу 1100 төгрөг хүртэл торговоос зохино (Баярсайхан, Монгол улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал, 2011), 83-р зүйлд “Тус улсын хязгаараас Шүүн таслах газрын тогтоолоор нэгэнт хөөгдсөн гадаад улсын харьяат нар хэрэв зоригоор эргэж ирвээс 1 жил хүртэл хорих буюу 600 төгрөг хүртэл торговоос зохимуй, 84-р зүйлд Аливаа шүүн таслах буюу захиран тушаах газруудын тогтоолоор заан суулгасан газраас өөрийн дур зоригоор зайлан гарагсдыг 100 өдөр хүртэл хорихгүйгээр албадан ажил үйлдвэр хийлгэх буюу 100 төгрөг хүртэл торговоос зохино, 88-р зүйлд Аливаа хүмүүн шүүн таслах газрын тогтоолоор ямарваа эрх чөлөөгөө хасуулсан байтал дураар зөрчиж эдэлбээс

300 төгрөг хүртэл торговоос зохимуй гэж хүлээлгэх хариуцлагыг тодорхойлсон.

Мөн хуулийн 11-р зүйлд торгуулийг төгрөгөөр тогтоож улсын ба орон нутгийн санд хурааваас зохимуй. Үнэхээрийн ядуу хоосон этгээдийг 100 төгрөгөөс хэтрүүлэхгүйгээр торгох бөгөөд хэрвээ уул зүйлийг төлөх чинээ үгүй ахул /бол/ даруй хорихгүйгээр албадан үйлдвэр хийлгэвээс зохих, үүнд 1 өдрийн ажлыг 1 төгрөгөөр бодож гүйцэтгэхээс гадна торгуулийн зүйлийг хуваарилах буюу тогтоосон хугацааг тогтоол гарсан өдрөөс эхлэн 1 жил хүртэл сунгаж болмуй. Үүнд тайлбарлах нь: Хөрөнгө бүхий этгээд ялыг шударгаар тушаахгүй зайлах болбоос түүний хувийн хөрөнгө хогшлыг албаны газраас данс тэмдэг үйлдэж худалдах буюу банкны зэрэг газар хадгалуулсан мөнгөн зоос, жич: бусдаас авах үйл буй аваас тэдгээрийг битүүмжлэх зэргээр төлүүлбээс зохимуй хэмээн хуульчилсан байх бөгөөд 1926 оны Шүүх цаазын бичгээс ялгаатай зохицуулалт нь торгууль төлж чадах хөрөнгө бүхий этгээд хэмээн албадлага хэрэглэх субъектийг илүү нарийн зааж өгсөн байдаг.

БНМАУ-ын 1934 оны Шүүх цаазын бичгийн Ерөнхий анги:

Шүүх цаазын бичгийг шинэчлэн зохиож, өөрчлөх нийгэм улс төрийн шаардлагаар Улсын бага Хурлын Тэргүүлэгчдийн газраас 1934 оны 05 дугаар сарын 24-ний өдөр Шүүх цаазын бичгийн ерөнхий ангийг 6 бүлэг 41 зүйлтэйгээр 1934 оны 10 дугаар сарын 08-нд тусгай ангийг 8 бүлэг 113 зүйлтэйгээр батлан гаргасан. Уг Шүүх цаазын бичигт Шүүхийн шийдвэр үл биелүүлэх гэмт хэргийн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой дараах заалтууд оржээ.

Шүүх цаазын 75-р зүйлд Алив хэргийн учир хоригдож буй ялтан хэрэгтэн нар харгалзуулсан манаанаас ба хорих газраас оргох буюу түүнчлэн сууж үл болох болохоор цаазлагдсан газарт дахин ирвэл 1 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэвэл зохино. Мөнхүү явдлуудыг олон удаа үйлдвэл 1 жилээс 3 жил хүртэл хорих ял шийтгэвэл зохино гэж тус тус заасан байдаг.

Энэ хуулийн зохицуулалтаар торгууль төлөөгүй этгээдэд хүлээлгэх хариуцлага өмнөх Шүүх цаазын бичгүүдэд зааснаас 40% хүртэл багассан байна. Тухайлбал өмнөх хуульд 1 өдрийн ажлыг 1 төгрөгөөр бодон тооцно гэсэн бол энэ хуулиар 50 төгрөг бүрийн төлөө нэг сар албадан ажил хийлгэх болгон гүйцэтгэж болно хэмээн зааснаас тодорхой харагдана.

БНМАУ-ын 1942 оны Эрүүгийн хууль:

Монгол Улсын 8 дугаар их хурал 1940 оны 6 сард шинэ Үндсэн хуулийг баталсан. Шинэ Үндсэн хууль батлагдсантай холбоотойгоор хууль, дүрмийг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд 1942 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр Улсын 25-р бага хурлаар БНМАУ-ын эрүүгийн хууль нэртэйгээр батлан гаргасан байна. Энэ нь Монгол Улсын эрүүгийн эрх зүйн түүхэнд анх удаа Эрүүгийн хууль гэсэн нэршилтэйгээр гарсан хууль юм. Эрүүгийн хуулийн ерөнхий анги нь 6 бүлэг 54 зүйлтэй, тусгай анги нь 10 бүлэг 165 зүйлтэй байжээ. Шинэ Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 29 дүгээр зүйлд, Шүүн таслах газрын тогтоолоор засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн ажлыг хийх явдлаас зайлсхийсэн хүн гарвал, өдрийг өдөрт бодож засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн ажлаас үлдсэн хугацааг нь хорих шийтгэлээр солино, мөн шүүх таслах газар нь ийнхүү таслан шийтгэсэн тогтоолыг сонинд бичих буюу өөр аргаар нийтлэхээр тогтоох эрхтэй болно гэж заасан. Энэ хуулийн нэг онцлог нь торгууль төлөөгүй этгээдэд хорих ял оногдуулахгүй болсон шинэ зохицуулалтыг шинээр хуульчлан баталгаажуулжээ.

Эрүүгийн хуулийн 103 дугаар зүйлд “Хоригдсон байгаа этгээд харгалзуулсан манаанаас ба хорих газраас оргох, мөн түүнчлэн сууж үл болох цаазалсан газар нутагт эргэж ирвэл гурван жил хүртэлх хугацаагаар хорьж шийтгэвэл зохино, заавал байрлавал зохих газар зааж суулгасан нутаг буюу тусгай суухыг цаазалсан газраас буюу түүнд очиж яваа замаас оргож зугтсан ба түүнчлэн засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн ажлаас зайлсхийсэн байвал шүүх таслах газрын магадлалаар цөллөг буюу засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн ажлыг мөн хугацаагаар хорих шийтгэлээр зохино” гэж шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг тодорхойлж өгсөн байна. Мөн хуулийн 170 дугаар зүйлд, Шүүн таслах газрын тогтоолоор хүүхэд багачуудын амьдарлагад олговол зохих зүйлүүдийг төлөхгүй санаатайгаар зайлсхийх ба мөн түүнчлэн эх, эцгээс хүүхдийг насанд хүрэхийн өмнө ямар ч тусламж тэтгэвэргүйгээр орхих бол гурван жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэвэл зохино гэж хүүхдийн тэтгэлэг төлөөгүй эцэг, эхэд хүлээлгэх хариуцлагыг анх удаа хуульчилснаараа ихээхэн онцлогтой хууль болсон.

БНМАУ-ын 1961 оны Эрүүгийн хууль:

БНМАУ-ын Ардын их хурлын 2 дугаар чуулганаар 1961 оны 1 дүгээр сарын 31-нд Эрүүгийн хуулийг баталж мөн оны 4 сарын 1-ний

өдрөөс дагаж мөрдсөн байна. Энэ хуульд шүүхийн шийдвэр үл биелүүлэх гэмт хэргийг 90 дүгээр зүйлд заасан бөгөөд иргэний хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй этгээдэд хариуцлага хүлээлгэхээр заасан бол 154 дүгээр зүйлд эрүүгийн хэргийн шүүхийн тогтоолыг биелүүлээгүй, биелүүлэхээс зайлсхийсэн этгээдэд хариуцлага хүлээлгэхээр заасан байна. Энэ хуулийн онцлог нь торгуулийн ялыг биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлага буюу засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялын дээд хэмжээг 1 жил 6 сар байхаар зохицуулсан байдаг.

Шинээр тусгасан өвөрмөц зохицуулалт нь нийгэмд аюултай гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүмүүст албадан хүмүүжүүлэх чанарын арга хэмжээг хэрэглэх бөгөөд шүүхээс оногдуулсан арга хэмжээ нь амжилт олохгүй байвал шүүх түүнийг хүүхэд багачуудыг хүмүүжүүлэх тусгай байгууллагад байлгахаар сольж болохоор мөн хуульд заасан нь шүүхийн шийдвэр биелүүлээгүй насанд хүрээгүй хүмүүст хүлээлгэх хариуцлагын тогтолцоог хуульд тусгасан явдал юм.

Энэ хуулийн 148 дугаар зүйлийг Шүүх, мөрдөн байцаах ба хэрэг бүртгэх байгууллагын шаардлагаас зайлсхийх буюу биелүүлэхгүй байх гэж нэрлээд ... Б. Энэ зүйлийн а-д дурдсан хүмүүс шүүх, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх байгууллагын шаардлагыг биелүүлэхэд саад хийвэл 3 сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу 200 төгрөг хүртэл торгох эсхүл олон нийтийн арга хэмжээ авхуулна.... хэмээн заасан нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, шийдвэр гүйцэтгэгчид ч хамаарах эрх зүйн зохицуулалт юм. Учир нь энэ хугацаанд шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх чиг үүрэг шүүхэд харьяалагдаж байсан билээ.

Мөн хуулийн 152 дугаар зүйлд “Шүүх, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх байгууллагын шийдвэрээр дансалсан битүүмжилсэн хөрөнгийг хариуцагч этгээдээс үрэгдүүлсэн буюу нуун дарагдуулсан байвал 1 жил 6 сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу эсхүл 1 жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэнэ”, 154 дүгээр зүйлд “Нутаг заагдсан этгээд заасан нутагт очих замаас буюу заасан нутгаас орговол 1 жил 6 сар хүртэл хугацаагаар хорьж эдлээгүй үлдсэн хугацаанд уг заасан нутагт суулгана, Нутаг зайлуулагдсан этгээд дур зоргоороо эргэж ирвэл 1 жил хүртэл хугацаагаар хорьж эдлээгүй үлдсэн хугацаанд уг нутгаас зайлуулна, Засан хүмүүжүүлэх ажлаас санаатайгаар зайлсхийвэл засан хүмүүжүүлэх ажил хийлгэж байгаа хугацааг хорих ялаар солих боловч 9 сараас хэтрүүлж

болохгүй” гэх зэргээр шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг тодорхойлсон байна.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын 1986 оны Эрүүгийн хууль:

БНМАУ-ын АИХ-ын тэргүүлэгчдийн 1986 оны 12-р сарын 5-ны 217-р зарлигаар БНМАУ-ын эрүүгийн хуулийг шинэчлэн найруулж баталсан байна. Энэ хуулийн 27 дугаар зүйлд Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялаас ноцтойгоор зайлсхийвэл шүүх уг ялын үлдэж байгаа хугацааг түүнтэй тэнцэх хугацааны хорих ялаар сольж болно, жинхэнэ хугацаат албаны цэргийн албан хаагчид оногдуулсан засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг хоёр сар хүртэл хугацаагаар сахилгын байранд байлгахаар солино гэж тус тус зохицуулсан байна. Хугацаат цэргийн албан хаагчид оногдуулсан засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг сахилгын хорих байранд хорих замаар эдлүүлж байгаа нь судлаач бидний анхаарлыг ихээхэн татаж байна.

Мөн хуулийн 29 дүгээр зүйлд “Үндсэн ялын чанартай оногдуулсан торгох ялаас ноцтойгоор зайлсхийвэл шүүх торгуулийн далан таван төгрөгийг засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялын нэг сартай тэнцүүлэн бодож, төлөгдөөгүй торгуулийг нэг жил зургаан сараас дээшгүй хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялаар сольж болно” гэж заасан. Энэ хуулийн шинэлэг тал нь 210 дугаар зүйлд “Дансалсан буюу битүүмжилсэн эд хөрөнгийг итгэмжлэгдсэн хариуцсан этгээд үрэгдүүлсэн, нуусан, бусдад шилжүүлсэн, хураагдвал зохих эд хөрөнгийг нуусан, завшсан бол нэг жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл хоёр мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ” гэж зааснаас харагдана. Тухайлбал шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар битүүмжилсэн эд хөрөнгийг итгэмжлэн хариуцсан этгээд эсвэл төлбөр төлөгч хураагдвал зохих хөрөнгөө нуун далдалсан үрэгдүүлсэн тохиолдолд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрлийг анх удаа зохицуулжээ.

Хуулийн 214 дүгээр зүйлд “Заасан нутгаас буюу заасан нутагт очих замаас оргосон бол нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ, нутаг зайлуулагдсан этгээд оршин суухыг хориглосон газар дур мэдэн эргэж ирсэн бол нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заасан нь өнөөгийн эрүүгийн хуулийн зорчих эрхийг хязгаарлах ял эдлэхээс зайлсхийх үйлдэлтэй төстэй байна. Мөн хуулийн 216 дугаар зүйлд “Шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолоор тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхээ хасуулсан этгээд таслан

шийдвэрлэх тогтоолыг биелүүлээгүй бол нэг мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ, тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хассан шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолыг ажилд авах, ажлаас халах эрх бүхий албан тушаалтан биелүүлээгүй бол нэг мянга таван зуу хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ” гэж эрх хасах ялыг биелүүлээгүй ялтан болон эрх хасах ялыг хэрэгжүүлэх үүрэг бүхий албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг журамласан байдаг.

***БНМАУ-д хорихоос өөр төрлийн зарим ял эдлүүлэх журам,
нөхцөлийн тухай дүрэм:***

Энэ дүрэм ”-ийн 9 дүгээр зүйлд “Тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасуулах этгээд болон албан тушаалтан тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял оногдуулсан шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлээгүй бол тэдэнд БНМАУ-ын Эрүүгийн хуулийн 216 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ” гэж хүлээлгэх хариуцлагыг маш тодорхой зааж өгчээ. Мөн дүрмийн 22 дугаар зүйлийг “Хураагдах эд хөрөнгийг нуусан буюу завшсан гурав дахь этгээдэд хүлээлгэх хариуцлага” хэмээн нэрлээд ялтнаас хураагдвал зохих эд хөрөнгө үйлдвэр, албан газар, байгууллага, иргэдэд байвал тэд энэ тухай шүүх болон санхүүгийн зохих байгууллагад мэдэгдэх үүрэгтэй, уг эд хөрөнгийг нуусан буюу завшсан байвал гэм буруутай этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэж заасан.

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэгжүүлэх тухай 1995 оны хууль: Монгол улсын Их хурлаас 1995 оны 12 дугаар сарын 11-ний өдөр баталсан бөгөөд энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр торгох, тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах, эд хөрөнгө хураах, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг эдлүүлэх, тэнсэгдсэн болон шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан ялтныг хянан харгалзах, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршиж байв.

Энэ хуулийн 11 дүгээр зүйлд, Ялтан эд хөрөнгө, цалин орлогоо нуух, бусдад хууль бусаар шилжүүлэх, үрэгдүүлэх, шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэлгүйгээр байнга оршин суугаа газраа дур мэдэн өөрчлөх зэргээр ял эдлэхээс ноцтойгоор зайлсхийвэл шийдвэр гүйцэтгэгч зохих шалгалт явуулж торгох ялыг хорих ялаар солих тухай саналыг шүүхэд гаргана, 12

дугаар зүйлд, Тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй гэм буруутай этгээдэд Эрүүгийн хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ, 15 дугаар зүйлд, Шүүхийн шийдвэрт хураахаар заасан эд хөрөнгийг үрэгдүүлсэн, нуусан, бусдад шилжүүлсэн, завшсан гэм буруутай этгээдэд Эрүүгийн хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ, энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас тухайн эд хөрөнгөд учруулсан хохирлыг хуульд заасан журмын дагуу нөхөн төлүүлж, улсын орлогод оруулна гэж эрүүгийн болон иргэний эрх зүйн хариуцлагыг хамтад нь хэрэглэхээр заасан байдаг.

Мөн хуулийн 19 дүгээр зүйлд, Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг өөр төрлийн ялаар солих тухай дараах байдлаар томьёолжээ. “Ялтан хөдөлмөрийн сахилгыг удаа дараа зөрчих, хөдөлмөрийн харилцааг цуцлахаар гэрээнд заасан зөрчил гаргах, ажлаа дур мэдэн орхих зэргээр ял эдлэхээс ноцтой зайлсхийвэл аж ахуйн нэгж байгууллага энэ тухай шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэх бөгөөд шийдвэр гүйцэтгэгч зохих шалгалт хийж засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг хорих ялаар солих тухай саналаа холбогдох баримт бичгийн шүүхэд шилжүүлнэ. Мөн хуулийн 22 дугаар зүйлд ял тэнссэнийг хүчингүй болгож ялыг биечлэн эдлүүлэх талаар “Ялтан хянан харгалзах хугацаанд хөдөлмөрийн сахилга, нийгмийн хэв журмыг зөрчсөн эсхүл захиргааны шийтгэлийн буюу сахилгын арга хэмжээ авагдсан бол ял тэнссэнийг хүчингүй болгож шүүхийн шийдвэрээр оногдуулсан ялыг биечлэн эдлүүлэх тухай аж ахуйн нэгж, байгууллага, иргэн хүсэлт, Засаг дарга, цагдаагийн байгууллага саналаа ялтны оршин суугаа газрын шүүхэд гаргана”, “Аж ахуйн нэгж, байгууллага иргэний хүсэлт, Засаг дарга, цагдаагийн байгууллагын санал, прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх Эрүүгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 6, 7 дахь хэсэгт заасны дагуу ял тэнссэнийг хүчингүй болгож шүүхийн шийдвэрээр оногдуулсан ялыг биечлэн эдлүүлэхээр шийдвэрлэж болно” гэж эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлагыг зааж өгсөн байна.

Эрүүгийн хуульд 1996 онд оруулсан нэмэлт өөрчлөлт:

Монгол Улсын Их Хурлаас 1996 онд Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд энэ өөрчлөлтөөр Шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх гэмт хэргийг 216 дугаар зүйлд “Хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн таслан шийдвэрлэх, тогтоол, шийдвэр, магадлал, шүүхийн буюу

шүүгчийн тогтоолыг санаатай биелүүлээгүй, эсхүл биелүүлэхэд зориуд саад учруулсан бол гурван жил хүртэл хугацаагаар хорих буюу тавин мянгаас хоёр зуун мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ” гэж томьёолжээ.

Монгол Улсын 2002 оны Эрүүгийн хууль:

Улмаар улс оронд өрнөсөн эрх зүйн шинэчлэлтийн хүрээнд Монгол Улсын Их хурлаас 2002 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр эрүүгийн хуулийг шинэчлэн баталсан мөн оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн байна.

Шинэчлэн батлагдсан эрүүгийн хуулиар гэмт хэргийн бүрэлдэхүүний онол, бүрэлдэхүүний шинжийг багтаасан байх талаар тусгасан бөгөөд энэ шинжээр нь гэмт хэрэг мөн эсэхийг тогтоох агуулга тусгаснаараа онцлогтой. Иймээс шүүхийн шийдвэр үл биелүүлэх, эцэг, эх, эхнэр, нөхөр, төрүүлсэн буюу үрчилж авсан хүүхдээ тэжээн тэтгэхээс ноцтой зайлсхийх гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжээр нь задлан үзлээ.

Эрүүгийн хуулийн 120 дугаар зүйлд Эцэг, эх, эхнэр, нөхөр, төрүүлсэн буюу үрчилж авсан хүүхдээ тэжээн тэтгэхээс ноцтой зайлсхийсэн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тусгасан. Тухайлбал “Хөдөлмөрийн чадваргүй эцэг, эх, эхнэр, нөхөр, төрүүлсэн болон үрчилж авсан хүүхдээ тэжээн тэтгэх талаар гарсан шүүхийн шийдвэр биелүүлэхээс ноцтой зайлсхийсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ” хэмээн заасан нь хүүхдийн тэтгэлгээ төлдөггүй этгээдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгосон явдал юм гэж судлаач бидний зүгээс үзэж байна.

Мөн хуулийн 258 дугаар зүйл. Шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх: Хууль тогтоогч Эрүүгийн хуулийн 258 дугаар зүйлд хоёр бие даасан гэмт хэргийг хуульчилжээ. Эрүүгийн хууль 258 дугаар зүйлийн 258.1 дэх хэсэгт “Шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх” хэргийг 258.2 дахь хэсэгт “Шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийх зорилгоор хөрөнгийн мэдүүлгээ санаатай буруу гаргах эд хөрөнгөө нуун дарагдуулах, бусдад шилжүүлэх” гэмт хэргийг хуульчилсан байна (Гантөмөр.Г, Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг, 2005) гэж үзээд гэмт хэргийн бүрэлдэхүүнийг дараах байдлаар тайлбарлажээ.

Шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн 258 дугаар зүйлийн 258.1 дэх хэсэг/

Объект: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх талаар тогтоосон журам, Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын хууль ёсны үйл ажиллагаа энэ гэмт хэргийн шууд объект болно.

Эрүү, иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмыг Монгол Улсын ЭБШХ, ИХШХШТХ, ШШГТХуулиар зохицуулна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэл нь иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр, эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийтгэх тогтоол, хуульд заасан тохиолдолд бусад байгууллагын шүүхээр баталгаажуулсан шийдвэр байна.

2002 оны 1-сарын 11-ны өдөр батлагдсан "Иргэний хэрэг шүүхэд шийдвэрлэх тухай" Монгол Улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт зааснаар шүүхийн хуулийн хүчин төгөлдөр шийдвэрийг иргэн, хуулийн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй. Мөн ЭБШХ-ийн 329 дүгээр зүйлийн 329.1 дэх хэсэгт "...Шүүхийн тогтоол, магадлал шүүгчийн захирамжийг аж ахуйн нэгж байгууллага, албан тушаалтан, иргэн заавал биелүүлэх үүрэгтэй...", Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 85 дугаар зүйлийн 85.2 дахь хэсэгт "Шийдвэр гүйцэтгэгчээс тавьсан хууль ёсны шаардлагыг санаатайгаар биелүүлэхгүй байгаа иргэн хуулийн этгээд, албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжтэй нь тогтоогдсон бол гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ..." гэж заасан байна (Гантөмөр.Г, Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг, 2005).

Объектив тал: Хэлбэрийн бүрэлдэхүүнтэй. Хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийтгэх тогтоол, шийдвэр, магадлал, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг а) санаатай биелүүлээгүй, б/ биелүүлэхэд нь зориуд саад учруулсан үйлдэл, эс үйлдэхүй байна (Гантөмөр.Г, Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг, 2005).

Шүүхийн шийдвэр гэдэгт эрүү, иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийтгэх тогтоол, шүүхийн тогтоол шийдвэр, магадлал, шүүгчийн захирамж хамаарна.

Шүүхийн шийдвэрийг санаатай үл биелүүлэх гэдэг нь Эрүү болон иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг хүндэтгэх шалтгаангүйгээр үл биелүүлсэн эсвэл зохих ёсоор биелүүлээгүй,

биелүүлэхээс татгалзсан, зайлсхийсэн үйлдэл эс үйлдэхүйг хэлнэ. Шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх нь: торгох ял шийтгүүлсэн этгээд торгуулийг хугацаанд нь төлөхгүй байх, төлөхөөс зайлсхийх, албадан ажил хийлгэх ял шийтгүүлсэн этгээд албадан ажил хийхгүй хийхээс зайлсхийх, эд хөрөнгө хураах ял шийтгүүлсэн этгээд шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байх зайлсхийх, шүүхээс эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ хэрэглэсэн этгээд уг арга хэмжээг /албадлагыг/ биелүүлэхгүй байх, зайлсхийх иргэний хэргийн хариуцагч шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байх, зайлсхийх, оршин суутаа газраа санаатай өөрчлөх шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанаас оргон зайлах зэрэг эс үйлдэхүйгээр илэрнэ.

Шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд зориуд саад учруулсан гэдэгт шүүхийн шийдвэр биелүүлэх үүрэг бүхий этгээдээс уул шийдвэрийг биелүүлэхэд нь үүрэг даалгавар өгөх, шийдвэр, үйл ажиллагааг нь зогсоох зэргээр саад учруулсан аж ахуйн нэгж, байгууллагын албан тушаалтан түүнчлэн шүүхийн шийдвэр гүйцэтгэгчээс албадан гүйцэтгэх ажиллагаа явуулахад нь цалин орлого, эд хөрөнгийг нуун дарагдуулах, хуурамч бичиг баримт бүрдүүлэх, худал мэдээлэл өгөх, шүүхийн шийдвэр биелүүлэх үүрэг бүхий этгээдийг нуух, оргон зайлсхийхэд тус дэмжлэг үзүүлэх зэргээр санаатайгаар саатуулсан албан тушаалтан, иргэдийн үйлдэл, эс үйлдэл хамаарна (Гантөмөр.Г, Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг, 2005).

Субъектив тал: Гэм буруугийн шууд санаатай хэлбэр байна.

Субъект: Тусгай субъекттэй гэмт хэрэг бөгөөд шүүхийн шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй этгээд тухайлбал: Эрүүгийн хэргийн хувьд торгох, албадан ажил хийлгэх, эд хөрөнгө хураах, тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял шийтгүүлсэн этгээд /ялтан/ иргэний хэргийн хувьд хариуцагч /төлбөр төлөгч/ мөн шүүхийн шийдвэрийг биелүүлэх үүрэг бүхий бусад этгээд байна.

Шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийх зорилгоор хөрөнгийн мэдүүлгээ санаатай буруу гаргах, эсхүл эд хөрөнгөө нуун дарагдуулах, бусдад шилжүүлэх гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн 258 дугаар зүйлийн 258.2 дахь хэсэг/

Объект: 258 дугаар зүйлийн 258.2 дахь хэсэгт заасан энэ гэмт хэргийн бүрэлдэхүүний хувьд объект нь 258.1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгтэй ижил байна.

Объектив тал: Хэлбэрийн бүрэлдэхүүнтэй.

Шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийх зорилгоор а/ хөрөнгийн мэдүүлгээ санаатай буруу гаргасан, б/ эд хөрөнгө нуун дарагдуулсан, в/ бусдад шилжүүлсэн үйлдэл, эс үйлдэхүй байна.

Хөрөнгийн мэдүүлгээ санаатай худал буруу гаргах нь иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд төлбөр төлөгч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 40 дүгээр зүйлд зааснаар эд хөрөнгийн мэдүүлгээ гаргахдаа өөрийн эд хөрөнгийн тоо хэмжээ, үнэ, шинж чанарын талаар худал мэдээлснийг хэлэх ба энэ нь эд хөрөнгийг нуух, дутуу мэдээлэх, эсвэл өөрт байхгүй хөрөнгийг нэмж мэдээлэх, эд хөрөнгийн гарал үүсэл, тоо ширхэг, үнэ өртөг, шинж чанарын талаар буруу мэдээлэх зэрэг хэлбэртэй байна.

Эд хөрөнгөө нуун дарагдуулсан гэдэгт Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд эд хөрөнгө хураах ял шийтгүүлсэн ялтан шүүхийн шийтгэх тогтоол магадлалд заасан эд хөрөнгийг, иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд төлбөр төлөгч төлбөр авагчид шилжүүлбэл зохих шүүхийн гүйцэтгэх хуудсанд заасан шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс зайлсхийх зорилгоор эд хөрөнгийг нуух, бүгдийг буюу заримыг өөр газар шилжүүлэх хуурамч гэрээ, хэлцэл байгуулж бусдын нэр дээр шилжүүлэх, бэлэглэх зохиомлоор өр, төлбөр үүсгэх зэргээр нуун дарагдуулсан үйлдлүүд хамаарна.

Эд хөрөнгөө бусдад шилжүүлэх гэж шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийх зорилгоор эд хөрөнгө хуураах ял шийтгүүлсэн этгээд, төлбөр төлөгч /төлбөр авагчид/ шилжүүлбэл зохих эд хөрөнгийг бусдад бэлэглэх, бусдын нэр дээр шилжүүлэх, худалдах, өр зээлд өгөх, бусдад зээлдүүлэх, хадгалуулах өөр хүний нэр дээр бүртгүүлэхийг хэлнэ.

Субъектив тал: Гэм буруугийн шууд санаатай, шунахай сэдэлттэй байна. Энэ гэмт хэргийн субъектив талын заавал байх нэг шинж нь шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс зайлсхийх гэсэн зорилго юм.

Субъект: Шүүхийн шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй этгээд байна.

Хүндрүүлэх нөхцөл байдал: Эрүүгийн хуулийн 258 дугаар зүйлийн 258.3 дах хэсэгт энэ хэргийг а/. энэ гэмт хэрэгт урьд шийтгүүлсэн этгээд үйлдсэн б/. зохион байгуулалттай бүлэг гэмт бүлэглэл үйлдсэн бол ялыг хүндрүүлэх нөхцөл байдал болно. Энэ гэмт хэрэгт "урьд нь ял шийтгүүлсэн этгээд үйлдсэн" гэдэгт зөвхөн ялтай давтан буюу рецидив гэмт хэргийг ойлгоно. Өөрөөр хэлбэл зөвхөн шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх хэрэгт

урьд нь ял шийтгүүлсэн этгээд ялаа эдэлсний дараа Эрүүгийн хуулийн 78-р зүйлд заасан үндэслэл, журмын дагуу ялгүй болоогүй, ялгүйд тооцогдоогүй байхдаа дахин энэ гэмт хэргийг үйлдсэнийг хамааруулна. Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн гэдэг нь шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 36 дугаар зүйлийн 36.4, 36.5 дахь хэсэгт заасан зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэнийг хэлнэ.

Тайлбар: Хууль тогтоогч 258 дугаар зүйлийн тайлбарт урамшуулсан хэм хэмжээг хуульчилсан байна. Энэ зүйлд заасан гэмт хэрэгт сэжигтнээр тооцогдсон яллагдагчаар тооцогдсон ял шийтгэгдсэн этгээд шүүхийн шийдвэр биелүүлсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлөхөөр заажээ.

Шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийх зорилгоор хөрөнгийн мэдүүлгээ санаатай буруу гаргасан, эсхүл эд хөрөнгөө нуун дарагдуулсан, бусдад шилжүүлсэн бол мөн энэ хэргийг гэмт хэрэгт урьд ял шийтгүүлсэн этгээд, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн бол хүндрүүлэн авч үзэхээр эрүүгийн хуульд заажээ. Шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийж энэ гэмт хэрэгт сэжигтнээр тооцогдсон, яллагдагчаар татагдсан, ял шийтгэгдсэн этгээд шүүхийн шийдвэрийг биелүүлсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөхөөр хуульчилсан нь хүний эрхийг хангасан сайн зохицуулалт болсон байна (Гантөмөр.Г, Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг, 2005).

Мөн хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн ялтан ял эдлэхээс зайлсхийсэн бол эрүүгийн хуулийн 47 дугаар зүйлд торгох ялаас ноцтойгоор зайлсхийвэл уг ялын хэмжээнээс хамааруулан шүүх торгох ялыг гурван жил хүртэл хугацаагаар хорих ялаар, 50 дугаар зүйлд албадан ажил хийлгэх ял эдлэхээс санаатайгаар зайлсхийсэн ялтны эдлээгүй үлдсэн ялын найман цагийн ажлыг нэг хоног баривчлах ялаар тус тус тооцож солих талаар заасан (Гантөмөр.Г, Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг, 2005).

Түүнчлэн тэнсэх албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд хариуцлага хүлээлгэх талаар тус хуулийн 61 дүгээр зүйлд тэнсэгдсэн ялтан хянан харгалзах хугацаанд захиргааны шийтгэл хүлээсэн бол цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн хорих ялыг биечлэн эдлүүлэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ, 62 дугаар зүйлд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан насанд хүрээгүй этгээд шүүхээс тогтоосон хугацаанд даалгасан үүрэг биелүүлээгүй буюу

захиргааны шийтгэл хүлээсэн бол шүүгч цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай захирамж гаргана, ялтан хүүхдээ асарч хүмүүжүүлэхээс зайлсхийсэн бол шүүх цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай шүүгч захирамж гаргана, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх буюу ганц бие эцэг хүүхдээ асарч хүмүүжүүлэхээс зайлсхийсэн бол шүүх цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай шүүгч захирамж гаргана гэж тус тус заажээ. (Гантөмөр.Г, Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг, 2005)

ДҮГНЭЛТ

Түүхэн эх сурвалжид шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хүлээлгэж байсан хууль зүйн хариуцлагын эрх зүйн зохицуулалтын талаар судлан үзэхэд эрүүгийн хууль тогтоомжоор түлхүү хариуцлага хүлээлгэж ирсэн байна. Шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалт 1961 оны Эрүүгийн хуульд анх удаа бие даасан гэмт хэрэг болж тусгагдсан байх бөгөөд 2002 оны Эрүүгийн хуульд энэ гэмт хэргийн шинжийг нэлээд дэлгэрэнгүй байдлаар авч үзсэн байна.

2002 онд батлагдсан эрүүгийн хуулийн агуулгаар шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлагыг үндсэн 2 шинжээр тусгаж өгсөн бөгөөд эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй буюу хорих, хорихоос өөр төрлийн ял оногдуулсан эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ хэрэглэсэн шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлагыг ... ял солих /хүчингүй болгох буюу хэрэгсэхгүй болгох зохицуулалтыг тусгах/..., агуулгаар тусгасан бол иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр, Захиргааны хэргийн дагнасан шүүх байгуулагдсантай холбоотойгоор захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тусгасан хэмээн үзэж болно.

Түүнлэн эцэг, эх, эхнэр, нөхөр, төрүүлсэн буюу үрчилж авсан хүүхдээ тэжээн тэтгэхээс ноцтой зайлсхийсэн этгээдэд хүлээлгэх

хариуцлагыг тусгасан явдал нь хүүхдийн эрхийг хангах онцгой зохицуулалт болжээ гэж үзлээ.

Манай улсын хувьд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулсан, шийдвэр гүйцэтгэгчийн хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй этгээдэд хууль зүйн хариуцлага хүлээлгэн гэмт хэрэгт тооцон ял оногдуулах, зөрчилд тооцон захиргааны шийтгэл оногдуулж ирсэн уламжлалтай байна гэж дүгнэлээ.

Эх сурвалж

Адъяабазар.Д. (1998). Монгол улсын 1921 оноос хойшхи хууль тогтоомжийн хөгжилт. Улаанбаатар: хэвлэх үйлдвэр.

Алтангэрэл.Т, Э. (2003). ХҮІ-ХҮІІІ зууны монгол цаазын бичгүүд. Улаанбаатар: хэвлэх үйлдвэр.

Амарсанаа. Ж, Б. Б. (2008). Монгол улсын хууль тогтоомжийн түүхэн товчоон. Улаанбаатар: хэвлэх үйлдвэр.

Баярсайхан, Б. (2011). Монгол улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал. Улаанбаатар: Хэвлэх үйлдвэр.

Болдбаатар.Ж, Л. (2009). Монгол улсын төр эрх зүйн түүхэн уламжлал. Улаанбаатар: хэвлэх үйлдвэр.

Гантөмөр.Г. (2005). Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг. Улаанбаатар: хэвлэх үйлдвэр.

Зая, А. (2016). Шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлага. Улаанбаатар: хэвлэх үйлдвэр.